ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/182/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827 Цахим хаяг:khulankhatanb@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 381

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.ГАНХЭТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 1,329,216.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 1,115,443.9 мянган төгрөгийг зарцуулан, орон нутгийн төсөвт 213,722.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,800.2 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,989.4 мянган төгрөг, нийт 15,789.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 12,928.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,861.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар 53,043.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 17,640.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 6,402.4 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 төлбөрийн акт, 29,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 80.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **161,361,790.00** | **146,870,370.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **725,000.00** | **1,500,000.00** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **725,000.00** | **1,500,000.00** |
| **3121** | **Төгрөг** | **725,000.00** | **1,500,000.00** |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 725,000.00 | 1,500,000.00 |
| **33** | **АВЛАГА** | - | **2,800,000.00** |
| **335** | **Бусад авлага** | - | **2,800,000.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 2,800,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 20,100,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 20,100,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **140,536,790.00** | **142,570,370.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **139,276,790.00** | **136,945,370.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,275,600.00 | 1,390,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 129,289,190.00 | 127,438,770.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 8,712,000.00 | 8,116,000.00 |
| 35600 | Мал амьтад | 1,260,000.00 | 5,625,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,374,975,923.93** | **2,695,435,051.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,374,975,923.93** | **2,695,435,051.83** |
| **392** | **Биет хөрөнгө** | **2,351,774,173.93** | **2,654,936,251.83** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,525,811,972.00 | 1,603,804,972.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (336,030,576.81) | (413,715,263.43) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 191,097,040.00 | 363,597,040.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (85,324,951.89) | (117,978,290.25) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 135,310,161.53 | 130,803,710.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (93,231,989.39) | (54,907,440.14) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 69,370,700.62 | 88,820,250.62 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,452,160.50) | (31,478,397.99) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,230,314,740.00 | 1,423,775,378.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (252,090,761.63) | (337,785,707.91) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **23,201,750.00** | **40,498,800.00** |
| 39301 | Програм хангамж | 2,410,000.00 | 2,110,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,066,250.00) | (2,110,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,858,000.00 | 40,498,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,536,337,713.93** | **2,842,305,421.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **20,527,630.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | **20,527,630.00** |
| **413** | **Өглөг** | - | **20,527,630.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 680,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | **19,847,630.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 13,718,100.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 6,129,530.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,536,337,713.93** | **2,821,777,791.83** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,536,337,713.93** | **2,821,777,791.83** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 399,748,482.67 | 417,389,282.67 |
| 51101 | Өмч: - төрийн | 399,748,482.67 | 417,389,282.67 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **2,082,235,958.11** | **2,350,035,236.01** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,082,235,958.11 | 2,082,235,958.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 267,799,277.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 54,353,273.15 | 54,353,273.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,536,337,713.93** | **2,842,305,421.83** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,192,731,473.00** | **1,873,087,805.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,010,400.00** | **528,081,637.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,010,400.00** | **528,081,637.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,010,400.00 | 523,416,637.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,010,400.00 | 1,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө | - | 522,416,637.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал | | 4,665,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,190,721,073.00** | **1,345,006,168.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **93,567,473.00** | **15,789,568.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 57,394,253.00 | 1,800,168.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,173,220.00 | 13,989,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,097,153,600.00** | **1,329,216,600.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 1,097,153,600.00 | 1,329,216,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,439,225,424.16** | **1,605,288,527.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,439,225,424.16** | **1,605,288,527.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,335,512,886.68** | **1,364,592,450.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **594,745,840.03** | **721,961,557.53** |
| 210101 | Үндсэн цалин | 308,602,818.12 | 344,871,018.94 |
| 210102 | Нэмэгдэл | 239,497,314.40 | 279,860,467.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,535,000.00 | 34,410,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 8,668,450.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,110,707.51 | 54,151,621.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,875,176.10** | **89,613,448.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,795,102.21 | 61,592,692.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,975,894.38 | 7,242,203.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,987,947.18 | 3,621,101.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,823,246.46 | 3,429,437.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,292,985.87 | 13,728,012.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **88,450,827.81** | **92,319,465.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,847,827.81 | 17,371,905.68 |
| 210302 | Түлш, халаалт | 74,613,000.00 | 74,613,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 990,000.00 | 334,560.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **41,377,462.98** | **26,518,410.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,955,450.00 | 1,663,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,401,453.00 | 18,118,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,023,389.98 | 3,949,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 871,000.00 | 783,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,126,170.00 | 2,002,310.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,814,600.00** | **111,300.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,814,600.00 | 111,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **92,970,200.00** | **25,233,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 420,000.00 | 129,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 92,550,200.00 | 25,103,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **21,128,000.00** | **22,130,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,128,000.00 | 22,130,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **69,029,930.00** | **95,437,550.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 66,825,610.00 | 93,185,076.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,334.00 | 304,134.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143,500.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 698,000.00 | 740,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 67,186.00 | 61,640.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **352,120,849.76** | **291,267,719.10** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 135,945,698.60 | 51,793,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 501,500.00 | 4,106,060.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 215,673,651.16 | 235,368,409.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **103,712,537.48** | **240,696,076.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **34,307,026.00** | **26,862,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,317,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 27,521,526.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,468,500.00 | 26,862,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **69,405,511.48** | **213,834,076.79** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 69,405,511.48 | 213,772,664.79 |
| 213405 | Нэмэлт дансны төвлөрүүлэх шилжүүлэг | | 61,412.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(246,493,951.16)** | **267,799,277.90** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,765,604.89** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,765,604.89 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(1,765,604.89)** | **-** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(248,259,556.05)** | **267,799,277.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,198,131,473.00** | **1,346,006,168.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,010,400.00** | **1,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,010,400.00** | **1,000,000.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **2,010,400.00** | **1,000,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,010,400.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,196,121,073.00** | **1,345,006,168.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **98,967,473.00** | **15,789,568.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 60,637,753.00 | 1,800,168.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 38,329,720.00 | 13,989,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,097,153,600.00** | **1,329,216,600.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,097,153,600.00 | 1,329,216,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,189,291,673.00** | **1,329,461,068.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,189,291,673.00** | **1,329,461,068.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,077,479,135.52** | **1,100,616,991.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **594,745,840.03** | **721,961,557.53** |
| 210101 | Үндсэн цалин | 291,673,348.72 | 301,615,652.95 |
| 210102 | Нэмэгдэл | 256,426,783.80 | 331,316,686.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,535,000.00 | 34,410,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 6,989,609.03 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,110,707.51 | 47,629,609.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **73,875,176.10** | **89,613,448.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,795,102.21 | 61,592,692.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,975,894.38 | 7,242,203.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,987,947.18 | 3,621,101.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,823,246.46 | 3,429,437.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,292,985.87 | 13,728,012.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **88,621,517.79** | **92,319,465.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,018,517.79 | 17,371,905.68 |
| 210302 | Түлш, халаалт | 74,613,000.00 | 74,613,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 990,000.00 | 334,560.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,061,770.00** | **25,947,080.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,599,450.00 | 1,211,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,963,750.00 | 18,617,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,852,700.00 | 3,849,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 871,000.00 | 783,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,774,870.00 | 1,485,030.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **754,600.00** | **1,948,300.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 754,600.00 | 1,948,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **73,868,500.00** | **23,754,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 420,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 73,448,500.00 | 23,254,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **21,128,000.00** | **21,450,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,128,000.00 | 21,450,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **69,715,333.00** | **76,551,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,511,013.00 | 74,299,326.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 281,334.00 | 312,558.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143,500.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 698,000.00 | 740,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 67,186.00 | 53,216.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **123,708,398.60** | **47,071,340.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 122,800,898.60 | 43,345,560.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 907,500.00 | 3,725,780.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **111,812,537.48** | **228,844,076.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **42,407,026.00** | **12,210,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,317,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 27,521,526.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,568,500.00 | 12,210,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **69,405,511.48** | **216,634,076.79** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 69,102,007.27 | 213,772,664.79 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 303,504.21 | 2,861,412.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,839,800.00** | **16,545,100.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,219,800.00** | **15,770,100.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,219,800.00** | **15,770,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,219,800.00 | 15,770,100.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 8,219,800.00 | 15,770,100.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(8,219,800.00)** | **(15,770,100.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 620,000.00 | 775,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 725,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 725,000.00 | 1,500,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 399,748,482.67 | 54,353,273.15 | 2,063,288,533.23 | | 2,517,390,289.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **399,748,482.67** | **54,353,273.15** | **2,063,288,533.23** | - | **2,517,390,289.05** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 18,947,424.88 | | 18,947,424.88 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **399,748,482.67** | **54,353,273.15** | **2,082,235,958.11** | - | **2,536,337,713.93** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **399,748,482.67** | **54,353,273.15** | **2,082,235,958.11** | - | **2,536,337,713.93** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **399,748,482.67** | **54,353,273.15** | **2,082,235,958.11** | - | **2,536,337,713.93** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 17,640,800.00 | - | - | | 17,640,800.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 267,799,277.90 | | 267,799,277.90 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **417,389,282.67** | **54,353,273.15** | **2,350,035,236.01** | - | **2,821,777,791.83** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,329,216,600.00** | **1,115,443,935.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,329,216,600.00** | **1,115,443,935.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,310,135,100.00** | **1,103,458,935.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **808,790,300.00** | **721,961,557.53** |
| 210101 | Үндсэн цалин | 325,436,000.00 | 301,615,652.95 |
| 210102 | Нэмэгдэл | 387,692,300.00 | 331,316,686.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 48,700,000.00 | 34,410,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 6,989,609.03 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 46,962,000.00 | 47,629,609.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **101,099,000.00** | **89,613,448.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,747,300.00 | 61,592,692.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,087,900.00 | 7,242,203.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,044,000.00 | 3,621,101.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,044,000.00 | 3,429,437.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,175,800.00 | 13,728,012.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **104,855,000.00** | **92,319,465.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,802,000.00 | 17,371,905.68 |
| 210302 | Түлш, халаалт | 74,613,000.00 | 74,613,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,440,000.00 | 334,560.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,052,100.00** | **21,861,960.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,200,000.00 | 1,211,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,000,000.00 | 14,532,330.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,000,000.00 | 3,849,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,045,000.00 | 783,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,807,100.00 | 1,485,030.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,807,100.00** | **1,948,300.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,807,100.00 | 1,948,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **53,528,300.00** | **39,524,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,585,200.00 | 500,000.00 |
| 210602 | Тавилга | 20,000,000.00 | 15,770,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 943,100.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 30,000,000.00 | 23,254,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **20,000,000.00** | **18,270,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,000,000.00 | 18,270,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **103,454,400.00** | **75,253,124.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хур | 99,331,400.00 | 73,000,650.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 622,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 536,400.00 | 312,558.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 245,600.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 740,400.00 | 740,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 963,500.00 | 53,216.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **79,548,900.00** | **42,706,980.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,000,000.00 | 41,942,880.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,548,900.00 | 764,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,081,500.00** | **11,985,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **19,081,500.00** | **11,985,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,081,500.00 | 11,985,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,329,216,600.00** | **1,115,443,935.21** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,329,216,600.00** | **1,115,443,935.21** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,329,216,600.00 | 1,115,443,935.21 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **15,789,568.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,789,568.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,928,156.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,085,120.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,085,120.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,180,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,180,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,298,676.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,298,676.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,364,360.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,402,680.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,961,680.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **2,861,412.00** |
| 213405 | Нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,861,412.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **15,789,568.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **15,789,568.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,800,168.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,989,400.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 17,640.8 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

1. Байгууллагын нэр дээр эзэмших эрхийн гэрчилгээтэй 17,640.0 мянган төгрөгийн газрыг үнэлж, бүртгэж авахдаа, үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнасан.

Аудитаар нийт 35,402.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 6,402.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 29,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

**3.1 Төлбөрийн акт**

1. Батлагдсан төсвөөс Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ойд 1,000.0 мянган төгрөгийн хандив өгсөн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Анхан шатны баримтын бүрдэлгүй, үндэслэлгүйгээр 5,027.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Шуудан холбооны зардлаас байгууллагын 25 ажилтанд 375.0 мянган төгрөгийн гар утасны нэгж олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:”, 12.1.1-д “үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн актын биелэлтийг тогтоосон хугацааны дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

**3.2 Албан шаардлага**

1. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас тус сумын 2-р багийн Дулаан толгод гэх газар нөхөн сэргээлт хийх 29,000.0 мянган төгрөгийн ажилд цахим тендер зарлаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

**3.3 Зөвлөмж**

Байхгүй.

Аудитаар илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Газар үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн | 1 | 17,640.8 | | | 1 | 17,640.8 | 1 | 17,640.8 | | | | |
| **Дүн** | 1 | 17,640.8 | 0 | 0,00 | 1 | 17,640.8 | 1 | 17,640.8 | 0 | 0,00 | 0 | 0,00 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаард-лага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хандив өгсөн | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | | | | | |
| Үндэслэлгүй тэтгэмж олгосон | 1 | 5,027.4 | 1 | 5,027.4 | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **6,027.**4 | **2** | **6,027.4** | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим тендер зарлаагүй | 1 | 29,000.0 | | | 1 | 29,000.0 | | |
| Нэгж олгосон | 1 | 375.0 | 1 | 375.0 | | | | |
| Дүн | 2 | 29,375.0 | | | 1 | 29,000.0 | | |
| **Нийт дүн** | **2** | **29,375.0** | **1** | **375.0** | **1** | **29,000.0** | **0** | **0.00** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаар-лалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 06 өдөр Дугаар 33-А2370452 ХЭА-2026/182/НА-СТА-ТИВ Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд батлагдсан төсвөөс Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ойд 1,000,000.00 (нэг сая) төгрөгийн хандив өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т “*Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох “ журмын 4.2.3.1-д “төрийн өмч, хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн.” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зөрчин хандивласан 1,000,000.00 (нэг сая) төгрөгийг буруутай шийдвэр гаргасан сумын Засаг дарга Г.Батболдоор төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ганхэт-д, хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 06 өдөр Дугаар 34-А2370452 Чингис хот
ХЭА-2026/182/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд батлагдсан төсвөөс анхан шатны баримтын бүрдэлгүй, үндэслэлгүйгээр 5,027,400.00 (таван сая хорин долоон мянга дөрвөн зуун) төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зөрчин олгосон тэтгэмжийн 5,027,400.00 (таван сая хорин долоон мянга дөрвөн зуун) төгрөгийг буруутай шийдвэр гаргасан сумын Засаг дарга Г.Батболдоор төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ганхэт-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 06 өдөр Дугаар 35-А2370452 ХЭА-2026/182/НА-СТА-ТШЗ Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд шуудан холбооны зардлаас байгууллагын 25 ажилтанд 375,000.00 (гурван зуун далан таван мянган) төгрөгийн гар утасны нэгж олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:"*, 12.1.1-д *"үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зөрчин олгосон нэгжний үнэ 375,000.00 (гурван зуун далан таван мянган) төгрөгийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ганхэтээр төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ганхэт, нягтлан бодогч Н.Номинчулуун нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 06 Дугаар 55-А237 0452 Чингис хот
ХЭА-2026/182/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас тус сумын 2-р багийн Дулаан толгод гэх газар нөхөн сэргээлт хийх 29,000,000.00 (хорин есөн сая) төгрөгийн ажилд цахим тендер зарлаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана”*. гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендер зарладаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ганхэт, нягтлан бодогч Н.Номинчулуун нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112